МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
World Health Organization
Representative Office for Mongolia

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРЫН ТАНДАЛТ

# Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар

- <u>Үйлчлүүлэгч</u> эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх, эмчилгээ, оношлогооны явцад авсан халдвар
- <u>Эрүүл мэндийн ажилтан</u> ажил үүргээ гүйцэтгэж байх явцад халдварт өртөхийг ЭТҮХХ гэж үзнэ. (WHO)

*Японы Олон Улсын Эрүүл Мэнд Анагаах Ухааны Үндэсний Төвийн Др.Охара Хироши-ийн сургалтын материалаас*

# ЭТҮХХ-ын тандалтын бодлого, зорилго:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization Representative Office for Mongolia

- Илрүүлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих;
- Зорилтод тандалт судалгаа хийх;
- Төр, хувийн хэвшлийн бүх ЭМБ хийх;



**Нийт халдварын 91 (75,8%) нь - УХТЭ, УГТЭ, УНТЭ-т бүртгэгдсэн.**

# ЭТҮХХ-ЫН УЛС, ОРНУУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization
Representative Office for Mongolia

- АНУ-д 2 сая
- Европын холбо – 7.1%
- Өндөр хөгжилтэй орнууд- 2-4%
- Хөгжиж буй орнууд- 11.6%
- Дэлхийн дундаж 5-10%



# Мэс заслын дараах халдварын түвшин

| Амаржих газрын нэр | Мэс заслаар төрсөн эх n-634 | Халдварт өртсөн n-70 | AR% |
|---|---|---|---|
| **”A” амаржих газар** | 179 | 28 | **15.6** |
| **“B” амаржих газар** | 349 | 35 | 10.0 |
| **“C” амаржих газар** | 106 | 7 | 6.6 |
| **Нийт** | | | **11.04** |

УЛААНБААТАР ХОТЫН ЗАРИМ АМАРЖИХ ГАЗАРТ ТӨРСӨН ЭХЧҮҮДИЙН МЭС ЗАСЛЫН ДАРААХ ШАРХНЫ ХАЛДВАРЫН ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГАА

# Эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн хугацаа



| Хугацаа | Тохиолдлын тоо | Эзлэх хувь % |
|---|---|---|
| 1-5 хоног | 26 | 37,1 |
| 6-10 хоног | 24 | 34.2 |
| 11-15 хоног | 12 | 17.1 |
| 17-20 хоног | 4 | 5.7 |
| 21-ээс дээш | 4 | 5.7 |
| Нийт | 70 | |

# Эмнэлзүйн шинж тэмдэг n-70



# Халдварын эрсдэлт хүчин зүйл

- Халдвараас сэргийлэх удирдамж, заавар мөрдө ажиллахгүй;
- ЭМА-ны гарын ариун цэвэр;
- Ариутгалын үйл ажиллагаан алдаа,
- Орчны цэвэрлэгэ халдваргүйжүүлэлт;
- Эмнэлгийн туслам үйлчилгээний ачаалал, ажилбарын төлөвлөлт гэх мэт дотоод зохион байгуулалт.



# Ариутгалын хяналт-Ариун багажаар тусламж үйлчилгээ үзүүлэх



| № | Ариутгасан зүйлийн нэр | Тоо хэмжээ | Ариутгасан хугацаа: Эхэлсэн цаг | Дууссан цаг | Ариутгалын аппаратаас гаргасан цаг | Сар өдөр | Ариутгал… ажилтаны … |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | мэс сет. | 39ш | $12^{30}$ 1/6. | $08^{30}$ 1/8. | $09^{00}$ 1/8 | I/6. I/6 I/6 | Дуламсү… |
| 2. | Дуран сет. | 42ш | —॥— | —॥— | —॥— | | |
| 1. | мэс сет | 17ш | $12^{30}$ I/20 | $08^{30}$ I/29. | $09^{00}$ I/22. | I/20 I/20 | Дулам… |
| 2. | Дуран сет. | 69ш | —॥— | —॥— | —॥— | I/29 I/29 I/29. | |
| 1. | мэс сет. | 78ш | $12^{30}$ 1/27 | $08^{30}$ 1/29 | $09^{00}$ 1/29 | | |
| 2 | Дуран сет. | 27ш | —॥— | —॥— | —॥— | | Дулам… |
| 1. | мэс сет. | 17ш | $12^{30}$ II/3. | $08^{30}$ II/5 | $09^{00}$ II/5 | II/5 II/6. | Дула… |
| 2. | Дуран сет. | 45.ш | —॥— | —॥— | —॥— | II/12 II/12 II/12. | |
| 1. | мэс сет. | 4ш 37 | $12^{30}$ II/10. | $08^{30}$ II/12. | $09^{00}$ II/12 | | Дула… |

# Тандалтын тухай ойлголт

- Мэдээллийг системтэйгээр цуглуулах,
- Цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийх, тайлбарлах, хариу арга хэмжээ авах,
- Дүн шинжилгээг эргэн түгээх үйл ажиллагааг хэлнэ.

Тандалтын тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг хариу арга хэмжээ авах, төлөвлөх, шийдвэр гаргахад ашиглана.

# ЭТҮХХ-ын тандалт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization Representative Office for Mongolia

## Өдөр бүр тандах:

- Мэс заслын тусламж авсан үйлчлүүлэгч (зөвхөн сонгосон мэс засал хамаарна);
- 48 цагаас дээш судасны гуурстай байсан үйчлүүлэгч;
- 48 цагаас дээш хугацаанд зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэн үйлчлүүлэгч;
- 48 цагаас дээш хугацаанд давсганд шээлгүүр тавиулсан үйлчлүүлэгч.

# Мэс заслын дараах шархны халдвар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization
Representative Office for Mongolia

| | 30 хоногийн хугацаанд тандалт хийх мэс заслын нэр |
|---|---|
| 1 | Хэвлийн хөндийн цүлхэн хавчих |
| 2 | Мөч тайрах мэс засал |
| 3 | Мухар олгойн мэс засал |
| 4 | Диализ хийх зорилгоор шунт тавих |
| 5 | Цөсний зам, элэг, нойр булчирхай |
| 6 | Гүрээний артерийн судасны дотор талыг тайрах мэс засал |
| 7 | Цөсний мэс засал |
| 8 | Бүдүүн гэдэсний мэс засал |
| 9 | Кесар мэс засал |
| 10 | Ходоодны мэс засал |
| 11 | Зүрх шилжүүлэн сулгах |
| 12 | Хэвлийн хөндийгөөр умай тайрах мэс засал |
| 13 | Бөөр шилжүүлэн суулгах |
| 14 | Нурууны зөөлөн эдийг тайрах мэс засал |
| 15 | Элэг шилжүүлэн суулгах |
| 16 | Хүзүүний мэс засал |
| 17 | Бөөрний мэс засал |
| 18 | Өндгөвчний мэс засал |
| 19 | Түрүү булчирхайн мэс засал |
| 20 | Шулуун гэдэсний мэс засал |
| 21 | Жижиг гэдэсний мэс засал |
| 22 | Дэлүүний мэс засал |
| 23 | Цээжний мэс засал |
| 24 | Бамбай булчирхайн мэс засал |
| 25 | Үтрээгээр умай тайрах мэс засал |
| 26 | Оношилгооны зорилгоор хэвлийн хөндий нээх |

| | 90 хоногийн хугацаанд тандалт хийх мэс заслын нэр |
|---|---|
| 1 | Хөхний мэс засал |
| 2 | Зүрхний мэс засал |
| 3 | Зүрхний титэм судас залгах шунт мэс заслын үед цээжний болон дотор талын зүсэлт |
| 4 | Тархины мэс засал |
| 5 | Нугас, нурууны бэхэлгээ |
| 6 | Хугарлын нээлттэй багасгах мэсзасал |
| 7 | Ивэрхийн мэсзасал |
| 8 | Түнхний хиймэл үе протез |
| 9 | Өвдөгний үе солих мэс засал |
| 10 | Пейсмикер тавих |
| 11 | Захын судасны мэс засал |
| 12 | Нугас, нуруунд дахин бэхэлгээ хийх |
| 13 | Ховдолд шунт тавих |

# Мэс заслын дараах шархны халдвар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization
Representative Office for Mongolia

1. “Мэс заслын зүслэгийн өнгөц хэсэгт үүссэн  шархны халдвар” гэдэг нь:

**Мэс засал хийснээс хойш 30 хоног дотор, зүслэг хийсэн талбайн арьс болон арьсан доогуурх эдийг хамарсан халдварын шалтгаант эмгэг өөрчлөлтийг хэлнэ.**

**Дараах  тохиолдлоос 1 буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдвэл**

- ✓ **Үжлийн эсрэг дэглэмийг баримтлан арьсан доогуурх эдээс авсан шинжилгээнд нян өсгөвөрлөгдөх;**
- ✓ **Нян өсгөвөрлөгдөөгүй ч эмч шархыг зориудаар нээсэн;**
- ✓ **Эмч мэс заслын дараах шархны өнгөц хэсэгт үүссэн халдвар гэж  оношилсон;**

Үйлчлүүлэгчид дараах шинж тэмдгээс 1 буюу түүнээс дээш шинж тэмдэг илэрвэл:

- ✓ Шархнаас идээ, үрэвслийн шингэн гарах;
- ✓ Шарх өвдөж, эмзэглэлтэй болох
- ✓ Зүслэг орчим хэсэг газарт хавдах;
- ✓ Зүслэг орчим улайх, халуу оргих;

# Мэс заслын дараах шархны халдвар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization Representative Office for Mongolia

1. **"Мэс заслын зүслэгийн гүний хэсэгт үүссэн шархны халдвар" гэдэг нь:**

**Мэсзасал хийлгэснээс хойш 30/90 хоног*дотор зүслэгийн гүний зөөлөн эд фасци, булчингийн давхаргыг хамарсан халдварын шалтгаант эмгэг өөрчлөлтийг хэлнэ.**

**Дараах тохиолдлоос 1 буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдвэл мэс заслын зүслэгийн гүний хэсэгт үүссэн шархны халдвараар бүртгэнэ.**

- ✓ **Эмч мэс заслын дараах шархны гүний хэсэгт үүссэн халдвар гэж оношилсон;**
- ✓ **Эмч шархыг зориудаар нээсэн;**

Үйлчлүүлэгчид дараах шинж тэмдэгээс 1 ба түүнээс дээш шинж тэмдэг илрэх:

- ✓ Зүслэгийн гүний хэсгээс идээ гарах;
- ✓ Гүний хэсэгт тавьсан урсгуур, гуурсаар идээ гарах;
- ✓ Шарх задрах;

# Мэс заслын дараах шархны халдвар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization
Representative Office for Mongolia

“Мэс заслын дараах эрхтэн, эрхтэн хоорондын зайд үүссэн халдвар” гэдэг нь:

Мэс заслын дараа 30 эсвэл 90 хоногийн дотор илрэх халдвар орох ба эрхтэнд болон эрхтэн хоорондын хөндийд үүссэн халдварын шалтгаант эмгэг өөрчлөлтийг хэлнэ.

Дараах тохиолдлоос 1 буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдвэл мэс заслын дараа эрхтэн, эрхтэн хоорондын зайд үүссэн халдвараар бүртгэнэ.

- ✓ Эрхтэн, хөндийн эд, шингэнээс нян өсгөвөрлөгдөх;
- ✓ Халдварын шалтгаанаар давтан мэс засалд орсон;

Эмч оношилсон;

Өвчтөнд дараах шинж тэмдэгээс 1 ба түүнээс дээш шинж тэмдэг илрэх:

- ✓ Эрхтэн, хөндийд тавьсан урсгуур гуурсаар идээ гарах (нээлттэй, хаалттай урсгуур гуурс, Э гуурс, СТ чиглүүлэгч гуурс гм);
- ✓ Эд, эсийн шинжилгээ, дүрс оношилгоо, багажийн шинжилгээнд буглаа болон халдварын бусад шинж илрэх;

# Судасны гуурстай холбоотой халдвар

Судсанд гуурс тавьснаас хойш 48 цаг болж байгаа үйлчлүүлэгчид өөр байрлалтай халдварын голомт илрээгүй тохиолдолд цусанд эмгэг төрөгч илэрч халдвар, хордлогын шинж илрэхийг хэлнэ.

| Тохиолдлын тодорхойлолт | Лабораторийн шалгуур |
| --- | --- |
| Дараахь шинж тэмдгүүдээс аль нэг нь илэрнэ.<br>Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах.<br>Артерийн даралт багасах (САД <90 мм рт.ст.)<br>Шээсний гарц багасна (>20 мл/цаг).<br>Судасны цохилт түргэснэ(>90 удаа/мин).<br>Арьсны өнгө өөрчлөгдөж, зэвхий саарал болно.<br><br>1 хүртэлх насны хүүхдэд аль нэг нь илэрнэ.<br>Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах, эсвэл 37 хэмээс бууна.<br>Апноэ эсвэл брадикарди<br>Арьс эрээнтэж, саарaлтана.<br>Хоол, хөхөндөө дургүйцнэ<br>Нойрмог, унтаа болно | Тодорхой байрлалтай халдвар илрээгүй байхад:<br>Цусанд эмгэгтөрөгч бичил биетэн ургана<br>Эсвэл<br><br>Цусанд дараалсан 2 удаагийн бичил амь судлалын шинжилгээгээр арьсны хэвийн бичил биетэн ургах<br>Эмчилгээний дараах сорьцонд үүсгэгч илрэхгүй байж болно |

# Судасны гуурстай холбоотой халдвар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization
Representative Office for Mongolia

## Судасны гуурстай холбоотой халдварыг тандах бүдүүвч

48 цаг болон түүнээс дээш хугацаанд судсанд гуурс тавиулсан /өөр халдвар байхгүй

↓

Дараах шинж тэмдгүүдээс аль нэг нь илрэх:

- Шалтгаангүй халуурна >38С.
- Даралт унана (систол <90 мм рт.ст.)
- Шээсний гарц багасна (>20 мл/цаг).
- Пульс түргэснэ (>90 удаа/мин).
- Арьс зэвхий саарал болно.
- Хоолондоо дургүй, унтаа болно

**Тийм** →

Цусанд бичил биетэн илрүүлнэ

**Тийм** ↓

Цусанд бичил биетэн дахин илрүүлнэ

**Тийм** ↓ Судасны гуурстай холбоотой халдвар

**Үгүй** ←

Гуурс тавьсан хэсэгт аль нэг нь илрэх:

- Арьс эмзэг
- Улайсан
- Тэмтрэхэд судас гүвдрүүтсэн
- Идээ гарсан, буглаатай

**Тийм** ↓

Захын судасны хэсэг газрын үрэвсэл, халдвар

# Шээлгүүртэй холбоотой халдвар

Шээлгүүртэй  холбоотой шинж тэмдэг бүхий  шээсний замын халдвар гэдэг нь шээлгүүр тавигдсанаас хойш 48 цагаас хойш

- нян судлалын шинжилгээнд 2-оос ихгүй төрлийн үүсгэгч ≥105КҮН/мл илрэх,
- умдагны дээгүүр өвдөх,
- шээсээ барьж чадахгүй байх,
- ойр ойрхон шээх, шээхэд өвдөх,
- ууц нуруу бүсэлхий давсаг орчмоор өвдөх,
- 65 ≤ насны хүн 38≤ хэмээс дээш халуурах зэрэг шинж тэмдгээс аль нэг нь илрэхийг хэлнэ.

# VAP- Уушигны хатгаа

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

World Health Organization Representative Office for Mongolia

Зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэнээс хойш 48 цаг болж байгаа үйлчлүүлэгчид уушгины хатгаа илрэхийг хэлнэ.

| | Шалгуур |
|---|---|
| Цээжний рентген зураг | Доорх үзүүлэлтээс аль нэг нь илрэх<br>Уушгинд сүүдэржилт, нэвчдэс эсвэл эдийн нягтрал үүсээд 72 цаг эсвэл түүнээс өмнө үүссэн байх<br>Уушгинд хөндий үүссэн байх |
| Системийн шинж тэмдгүүд | Доорх үзүүлэлтээс аль нэгнь илрэх<br>Сүүлийн 24 цагийн дотор биеийн халуун 38 хэмээс ихэссэн<br>Сүүлийн 24 цагийн дотор цагаан эс 4000-аас бага, эсвэл12000-аас их байх (WBC/$mm^3$) |
| Уушгины талаас илрэх өөрчлөлт | Бүгд илрэх<br>48 цагийн турш агааржуулалтын $FiO_2$> 15 мм МУБ-аас тогтмол ихсэх ЭСВЭЛ 48 цагийн турш агааржуулалтын PEEP ≥ 5 см $H_2O_2$-аар тогтмол ихсэх<br>ЭСВЭЛ FiO2> 10 мм МУБ огцом ихсэх, 48 цагийн турш PEEP > 2.5 см $H_2O_2$ –аар ихсэх<br>Уушгины шүүрлийн сорьцонд нян илрэх мөн сүүлийн 72 цагийн турш ≥ 25 нейтрофиль илрэх |

# Тандалтын тоон мэдээллийн үзүүлэлт



- Тохиолдлын тоо
  - Бодит тоо,
  - Өвчлөлийн түвшин
  - Хувь
  - Хөдөлгөөнт дундаж

- Тархвар зүйн муруй
  - Халдвар эхэлсэн хугацаа
  - Ихсэлт, бууралт ...

## Тохиолдлын тоо



# Тандалтын тоон мэдээллийн үзүүлэлт

ЭТҮХХ-ын мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх:

- Мэс заслын тусламж авсан,
- Шээлгүүр,
- Судасны гуурс тавиулсан,
- Зохиомол амьсгалын аппаратаар дэмжигдсэн үйлчлүүлэгч бүрт тохиолдлын тодорхойлолтод нийцсэн халдварын тохиолдлын мэдээг цуглуулна.

Халдварт өртөлтийн түвшинг тооцохдоо ЭТҮХХ-т өртсөн үйлчлүүлэгчийн тоог тухайн сард (жилийн тайлан гаргаж байгаа бол жилийн хугацаанд) ижил тусламж, үйлчилгээ, ажилбар хийлгэсэн нийт үйлчлүүлэгчийн тоонд харьцуулж гаргана.

# Бусад тандалт

1. Эрсдэлтэй бүлгийн үйлчлүүлэгчид ЭТҮХХ илрүүлэх
   - Эрхтэн шилжүүлэн суулгасан, дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгч;
   - Диализ эмчилгээнд тогтмол орж байгаа үйлчлүүлэгч;
   - Төрсөн эх, нярай; Эх нярайн халдвар илрүүлэх тандалтыг өдөр бүр хийх шаардлагагүй
2. Гепатитын B, C вирусийн цочмог халдварын тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээний хамаарлыг тандах

# АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА